



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар 0198

Улаанбаатар хот

Тээврийн хэрэгсэл бүртгэн авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан, нийт 1,291,980,000 (нэг тэрбум хоёр зуун ерэн нэгэн сая есөн зуун наян мянга) төгрөгийн үнэ бүхий, хавсралтад заасан тээврийн хэрэгслийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2. Хавсралтад заасан тээврийн хэрэгслийг бүртгэн авч, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг эзэмшигч байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Д.СУМЪЯАБАЗАР



1110202303

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
 02 дугаар сарын 4-ны өдрийн
 4/578 захирамжийн
 хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭН АВАХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

| д/д | Хөрөнгийн нэр | Марк | Улсын дугаар | Арлын дугаар | Үйлдвэрлэсэн он | Бүртгэх үнэ (төгрөгөөр) | Хөрөнгө оруулалтын эх үүсвэр | Эзэмшигч байгууллагын нэр |
|----------|------------------------------|-----------|--------------|-------------------|-----------------|-------------------------|-----------------------------------|---|
| 1 | Крантай автомашин | Dong Feng | 19-53 УАР | LGDCM91L6MH131522 | 2023 | 98,780,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Хан-Уул дүүргийн Хан-Уул зам засвар, арчлалт ОНӨААТҮГ |
| 2 | Тусгай зориулалтын автомашин | Камаз | 62-15 УНИ | ХТС43253RN1474097 | 2022 | 347,050,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ |
| 3 | Тусгай зориулалтын автомашин | Камаз | 62-14 УНИ | ХТС43253RN1474100 | 2022 | 347,050,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Хан-Уул дүүргийн Тохижилт үйлчилгээний төв ОНӨААТҮГ |
| 4 | Экскаватор | Hyundai | 80-71 УР | ННКНМ907РЕ0008058 | 2014 | 154,000,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Сонгинохайрхан дүүргийн Захирагчийн алба ОНӨААТҮГ |
| 5 | Экскаватор | Hyundai | 80-70 УР | ННКНМ907CF0008650 | 2015 | 154,000,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Сонгинохайрхан дүүргийн Захирагчийн алба ОНӨААТҮГ |
| 6 | Крантай автомашин | Hino | 80-76 УЕК | FEIJLE10716 | 2003 | 95,550,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Сонгинохайрхан дүүргийн Захирагчийн алба ОНӨААТҮГ |
| 7 | Крантай автомашин | Nissan | 80-74 УЕМ | PK251KZ00164 | 1996 | 95,550,000 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалт | Сонгинохайрхан дүүргийн Захирагчийн алба ОНӨААТҮГ |
| Нийт дүн | | | | | | 1,291,980,000 | | |